



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/426

Арвайхээр

Эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 09 дүгээр сарын 18-ний өдрийн 13/03 тоот "Аймгийн 2020 оны төсөвт тодотгол хийх" тухай тогтоолын 2 дугаар хавсралтын 2.8 заалтад тусгагдсан төрийн байгууллагуудын автомашины шинэчлэл төсөл арга хэмжээний зардлаас санхүүжигдэх Уянга суман дахь сум дундын Цагдаагийн тасаг, Бат-Өлзий, Хужирт сумд дахь Цагдаагийн тасагт автомашин худалдаж авах зардалд тус бүр 33,000,000 (гучин гурван сая) төгрөг, нийт 99,000,000 (ерэн есөн сая) төгрөг, Баруунбаян-Улаан, Зүүнбаян-Улаан сумдын Эрүүл мэндийн төвд автомашин худалдаж авах зардалд тус бүр 13,000,000 (арван гурван сая) төгрөг, нийт 26,000,000 (хорин зургаан сая) төгрөг, Тарагт сумын 5 багт мотоцикль худалдаж авах зардалд тус бүр 2,000,000 (хоёр сая) төгрөг, нийт 10,000,000 (арван сая) төгрөг, бүгд 135,000,000 (нэг зуун гучин таван сая) төгрөгийг зарцуулах эрхийг холбогдох сумдын Засаг нарт шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100959